

Агуу гайхамшигт Аароны санваар

Залуу Эрэгтэйчүүдийн Ерөнхий Ерөнхийлөгч
Давид Л.Бек

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх тулгамдсан хэрэгцээ та бүхэнд бий. Энэ үүргээ та нар биелүүлнэ гэдэгт би итгэлтэй байна.

Өнөө орой Сүмийн гайхамшигтай залуу эрэгтэйчүүдэд хандан үг хэлэх болсон нь миний хувьд хүндэтгэлтэй хэрэг билээ. Миний бие дэлхий даяар та нараас олонтой нь нүүр учран уулзахаар адислагдсан хүн. Та нарын урам зориг бусдад нөлөөлдөг.

Та нар тулгарсан сорилт бэрхшээлийг ер бусын хүч чадал, зоригтойгоор даван туулдаг. Та нарт би хайраа илэрхийлж байна. Би та бүгдэд итгэдэг.

Та нар эргэн тойрон дахь хүмүүст төсөөлж байгаагаасаа илүү ихээр сүнслэг нөлөө үзүүлдэг. Аароны санваартан найзыгаа дүрслэн өгүүлэхийг хичээсэн манай сүмийнх биш нэг залуу эрэгтэйн үгсийг сонсоцгооё:

“Люис нэг л өөр болохыг би ажиглалаа. Энэ залуу бусад хүмүүсээс шал ондоо...Тэр нэг л өөр болохыг та ч гэсэн харж чадна. Чухам юу вэ гэдгийг би мэдэхгүй. Гэхдээ л тэр хүн бусдаас өөр. Тэр ялгаа нүдэнд харагдах зүйл биш. Харин мэдрэх зүйл. Та ч гэсэн мэдэрнэ дээ.”

Люис та хоёрыг бусад залуу эрэгтэйчүүдээс ялгаатай болгодог маш чухал зүйл байдаг. Та хоёр Аароны санваар авсан. Энэ бол ариун бэлэг бөгөөд олон хүн энэ санваарын агуу шинж чанарыг бүрэн ойлгодоггүй. Өнөө орой Аароны санваарын

агуу гайхамшгийг та нар өөрсдөө хэрхэн олж мэдэхэд би та нарт туслах болно.

1. Бурхан та нарт итгэдэг.

Бурхан та нарт Өөрийн ариун санваарыг итгэмжлэн олгосноор та бүхэнд агуу найдвар тавьдаг. Тэрээр бусад залуу эрэгтэйчүүдээр Өөрийнхөө хамгийн чухал ажлын заримыг хийлгэхэд итгэсэн шигээ та нарыг санваараа бусдад үйлчлэхэд зориулна гэдэгт итгэдэг.

Жишээ нь, Бурхан итгэл хүлээлгэсэн тэр хоёр залуу эрэгтэй байгаагүй бол Есүс Христийн хүчтэй гэрчлэл Мормоны Ном дэлхийд байхгүй байх байсан. Энэхүү ариун цэдгийг орчуулсан бошиглогч Мормон, ард түмнийхээ түүхийг ажиглаж, цэдэг бичих үүргийг авахдаа дөнгөж 10-аадхан настай байжээ. 15-тай байхдаа тэрээр “Их Эзэнээр зочлогдон, мөн Есүсийн сайн сайхныг амталж мөн мэдэв” (Мормон 1:15).

Иосеф Смит Мормоны Номыг орчуулж, хэвлүүлсэн. Түүний 14 настай байхад Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр түүн дээр хүрч ирэн, агуу ажилдаа түүнийг дуудсан билээ.

Ерөнхийлөгч Монсон ингэж хэлжээ:

“Агуу зүйлс та нарыг хүлээж байна. . . Их Эзэний үг хүчит бүрэн дуу мэтээр та нарт, надад, мөн газар бүр байх санваартнуудад хүрч, “Иймийн тул, эдүгээ хүн бүр өөрийн үүргийг мэдэж аваг, тэрээр томилогдсон албан тушаалдаа бүхий л хичээл зүтгэлээр ажиллаг” хэмээн уриалдаг.(“The Call for Courage,” Лиахона, 2004

оны 5-р сар, 54, 57).¹

II. Бурханы өмнө хүлээх үүрэг шинэ хөтөлбөр

Энэхүү яаралтай уриалгад хариу өгөхөд чинь туслахаар Сүм Бурханы өмнө хүлээх үүрэг шинэ хөтөлбөрийг нэвтрүүлж байна. Энэ тухай Ерөнхийлөгч Хенри

Б.Айринг өнөөдөр зарласан. Би энэ хөтөлбөрт баяртай байна. 6 -р сарын эхээр материалуудыг нь бишопуудад илгээх болно. Та бүхэн үүнийг хүлээж авангуутаа хэрэгжүүлж эхлэх хэрэгтэй.

Дикон, багш, прист та нар сүнсний хүч чадлаа төлөвшүүлж, санваарын үүрэгтээ суралцаж, биелүүлэхэд чинь туслах үйл ажиллагаануудад оролцох болно. Үйл ажиллагаа бүр нь дараах энгийн загварыг баримталдаг:

Та бүхэн эхлээд сайн мэдээний зарчмууд болон санваартны үүргүүдээ **мэдэж ав**.

Бурхан та нараар юу хийлгэхийг хүсч байгааг олж мэд. Энэ нь яагаад чухал болох тухай сүнсний гэрчлэлтэй болохыг хичээ.

Дараа нь сурсан зүйлээ хэрэгжүүлэх төлөвлөгөө гарга. Төлөвлөгөөгөө өөрсдийн хэрэгцээ, нөхцөл байдал, бусдад үйлчлэх боломжууд дээр тулгуурлан хийхийг бид урамшуулан дэмжиж байна. Энэ бол хувийн өсөлт хөгжилтдөө хариуцлага хүлээх, сүнслэг байдлын хувьд бие даах чадварыг хөгжүүлэх гайхамшигтай боломж юм.

Тэгээд дараа нь сурч мэдсэн зүйл болон туршлагаасаа бусадтай **хуваалц**. Үүнийг хийснээр, та нар гэрчлэлээ бэхжүүлэн, эргэн тойрон дахь хүмүүст итгэлийг бий болгоно. Сайн мэдээний талаар бусадтай ярилцах чадвараа нэмэгдүүлнэ.

¹

Дараах туршлагыг надтай хуваалцсан нэг залуу эрэгтэйд би талархаж байна.

Тэрээр өөр нэгэн Аароны санваарантай хамт, гэрээсээ гарч чадахгүй байгаа өвчтэй

нэг хүнд ариун ёслолыг адисалж түгээх даалгавар авчээ. Саяхан хийлгэсэн

эмчилгээ нь түүнийг юу ч идэж болохгүй, тэр битгий хэл ариун ёслолын жижиг

талхыг ч идэхийг хориглосон байв. Тэд үүнийг мэдээгүй байж. Талхыг адисалсны

дараа, залуу эрэгтэй ариун ёслолыг бие нь сул дорой болсон нөгөөх өвчтөнд өгсөн

гэнэ. Тэр адислагдсан талхны жижиг хэсгийг аваад, түр зуур хүлээснээ, уруулдаа

хүргэсэн аж. Итгэлтэй энэ ах бишрэл хүндэтгэлээ ариун ёслолд илэрхийлэхийг

хараад, тэрээр Аврагчийн хөлийг үнсэхийг харсан мэт мэдрэмж төрсөн хэмээн

залуу эрэгтэй ярьж билээ. Тэрээр Аврагчид хайртай гэдгээ хэлжээ.

Тэр өдрийн ариун ёслолын ач холбогдол энэ залуу эрэгтэйд мартагдашгүй ул

мөрөө үлдээсэн ажээ. Энэ залуу эрэгтэйд тохиолдсон шиг эрхэм ариун туршлага та

нарт бас тохиох болно.

Эцэг эх, удирдагчид, чуулгын гишүүд Бурханы өмнө хүлээх үүрэг хөтөлбөрт

чухал үүрэг гүйцэтгэдэг. Ням гарагийн чуулгын цуглаанууд тань сурах, ажиллах,

хуваалцах байнгын боломжуудаар та нарыг хангадаг. Бурханы өмнө хүлээх

үүргийн шинэ хөтөлбөр нь Бурханы өмнө хүлээх үүргээ хэрэгжүүлэх аянд та

нарыг хөтлөх болно. Тэрбээр Аароны санваарын аугаа гайхамшгийг нээн олоход

тань мөн хөтөлнө.

III. Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүл

Та нарыг болон Аароны санваарыг үзэх миний үзэл бодлыг эгнэгт өөрчилсөн аян

зам дээр би өнгөрсөн жилийн турш байлаа. Миний олж мэдсэн зүйлсийг та нар өөрсдөө олж мэдэх болсонд сэтгэл догдлон хөдөлж байна. Та нарын амьдралд Аароны санваар яагаад амин чухал вэ гэдгийг мөн энэ нь Сүмд яагаад чухал вэ гэдгийг та нар мэдэх болно. Санваар яагаад нэг “үндсэн төрөл зүйл ” байдгийг ойлгох болно. (С ба Г 107:6-г үз). Санваарын түлхүүрүүд, тэнгэр элчүүдийн тохинуулал, бэлтгэл сайн мэдээний утга учрыг илүү сайн ойлгох болно. (С ба Г 13, 84:26-г үз).

Сатан та нарыг нялх балчраараа байна, Аароны санваараараа чухал зүйлсийг гүйцэлдүүлэх хүн та нарын дотор хуруу дарам цөөхөн байна гэж бодогдуулахыг хичээх болно. Үүний аль нь ч үнэн биш юм.

Мосед хэлсэн Бурханы үгс өнөөдөр та нарт зориулагдсан юм. “Мөн, болгоогтун, чи миний хүү билээ; ... мөн чамд зориулсан ажил надад буй” (Мосе 1:4, 6).

Бурхан та нарт агуу зүйлсийг хийх Өөрийн хүчийг өгсөн юм. Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлснээр, та нар гэр бүлээ бэхжүүлж, адислах болно. Энэ бол та нарын санваарын хамгийн агуу үүрэг юм. Гэр бүлдээ үзүүлсэн хүүгийнхээ нөлөөг дүрслэн өгүүлсэн эх хүний үгийг сонс доо:

“Манай гэр бүлд Лео санваартай. Энэ бол маш том адислал юм. Тэрээр дүү нартаа сайн жишээ үзүүлж... тэднийг үргэлж залбирдаг байхад санаа тавьдаг. Ням гараг

бүр тэр ариун ёслолыг түгээнэ. Дүү нь түүнээс үлгэр жишээ авдаг. Тэрээр гэр бүлийн залбиралд тусална. Өсч том болохын хэрээр тэр бидэнд үргэлж адислал байх болно гэдгийг би мэдэж байна. Тэр эрэгтэй дүүдээ баптисм хүртээх болно. Энэ бол бидний хувьд тайтгарал бас бэлэг юм.”

Та нар Бурханы өмнө хүлээх үүргээ биелүүлснээр, Сүмийн гишүүн биш найз нартаа гараа сунган Сүмд элсэхэд бэлтгэхэд нь тэдэнд туслах болно. Та нар жинхэнэ ахын адилаар тэднийг харж хамгаалан, бэхжүүлдэг. Замаасаа гажсан бусад залуу эрэгтэйчүүдийг аврах ажлыг та удирдан манлайлах болно.

Та нар Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлснээр, цаг тутам, ямар ч нөхцөлд бусдад сайн нөлөө үзүүлэх болно. Зөв шударга үлгэр жишээ, санваарын итгэлтэй үйлчлэл тань та нарыг мэддэг хүмүүсийг Христэд ирэхийг урихад хүчирхэг арга хэрэгсэл байх болно.

Шийдвэрлэх цаг мөчид нифайчууд удирдлага, сүнслэг нөлөөний төлөө залуу эр Мормонд итгэл найдвараа тавьсан юм. Өнөөдөр, бид та нарыг Сүмийн агуу хүч, дэлхий дээр сайн сайхан байдлыг бий олгох хүч байхын төлөө итгэл найдвараа та нарт тавьж байна. Энэ бол Их Эзэн та нараас хүсэн хүлээдэг зүйл юм.

IV. Итгэлтэй санваартанг ологтун

Итгэлтэй санваартан болсноор зүрх сэтгэл тань өөрчлөгдөхийг та нар мэдрэх болно гэдгийг би гэрчилж байна. Та нар бүрэн цэвэр ариун болсноор ариун ёслолыг зохистойгоор адислан түгээхийг эрмэлзэх болно. Та нар залуу эмэгтэй нэг бүрийг хүндлэн мөн тэдэнд нинжин сэтгэлээр хандаж, эцэг эхээ дээдлэн хүндлэх болно.

Та нар юу бодож. юу хэлж байгаагаараа, мөн үйл хэргээрээ Сүнснийг гомдоохоос зайлсхийх ёстой. Та нар өөрсдийн үйлчилдэг Их Эзэнийг таньж мэдэн, Түүнтэй илүү адилхан болохыг үргэлж хичээх болно.

Аароны санваартан та нарын итгэлтэй үйлчлэл үйлчилдэг хүмүүсийн тань амьдралыг өөрчлөх болно гэдгийг би гэрчилж байна. Та нарын санваарын үйлчлэл хэрэгтэй хүмүүс байгаа. Та нар гэр бүлдээ хэрэгтэй. Та нар чуулгадаа хэрэгтэй. Та нар Сүмд хэрэгтэй. Та нар дэлхийд хэрэгтэй.

Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх зайлшгүй хэрэгцээ та бүхэнд байна. Та нар үүнийг хийнэ гэдэгт би бат итгэлтэй байна.

Хэдэн долоо хоногийн өмнө нэгэн хүйтэн өглөө, би Португалийн Лисабонд Тагус голын эргээр шогшин гүйх үедээ, олон зууны тэртээ Португалийн хайгуулчдад зориулан босгосон хөшөөг харж билээ. Нар мандан энэ сүрлэг хөшөө над дээр дулаан гэрлээ цацруулан тусгахад би зогслоо. Ус ширтэн харах хайгуулчдын шийдэмгий нүүр царай надад урам зориг оруулж билээ. Өмнө нь хэдхэн хүн хийсэн зүйлсийг эдгээр хүмүүс хийх хүсэлтэй байжээ. Тэд тохь тухтай, дассан амьдралаа орхин, урьд өмнө нь аялж үзээгүй их далайд зориглон хөдөлж, шинэ газар нутгийг нээн, дэлхийг өөрчилсөн юм.

Эрэлхэг зоригт хайгуулчдад зориулсан дурсгалын хөшөөг санахдаа би та нарыг хардаг. Энэ дэлхийд цөөхөн хүмүүс үргэлж дагахаар сонгосон тэрхүү аяны зам дээр би та нарыг хардаг. Та нар Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байгааг би хардаг.

Бид бүгдээрээ агуу гайхамшигт Аароны санваарыг авч явдаг хүмүүст Бурхан
итгэдгийн адил энэхүү санваарт итгэн үүнийг ойлгох болтугай хэмээн би залбирч
байна болно. Есүс Христийн нэрээр, амен.